

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/225/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amargjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал:
С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn





**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: mv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 01/103

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтод зориулан хөрөнгө оруулалт хийгдэж 181,207.8 мянган төгрөгийн үнэтэй тайз, аппаратур, техник хэрэгсэл, хөгжим, тавилга, 322,566.0 мянган төгрөгийн хувцас, жижиг хэрэглэл зэргийг хүлээн авч Засаг даргын Тамгын газрын А/392 тоот захирамжийн дагуу үндсэн хөрөнгө болон бараа материалын дансанд орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөр 5 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	345,929,749.83	737,721,533.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,092,804.56	18,090,528.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,092,804.56	18,090,528.51
3121	Төгрөг	4,092,804.56	18,090,528.51
31211	Төрийн сангийн харилцах	4,092,804.56	18,090,528.51
33	АВЛАГА	2,348,602.17	22,525,227.62
335	Бусад авлага	2,348,602.17	22,525,227.62
3351	Байгууллагаас авах авлага	2,025,025.52	22,351,650.97
3352	Хувь хүмүүсээс авах авлага	323,576.65	173,576.65
35	БАРАА МАТЕРИАЛ	339,488,343.10	697,105,777.10
351	Түүхий эд материал	272,029,753.00	603,114,153.00
35110	Тусгай зориулалттай материал	272,029,753.00	603,114,153.00
354	Хангамжийн материал	67,458,590.10	93,991,624.10
35410	Бичиг хэргийн материал	3,851,330.00	3,851,330.00
35420	Аж ахуйн материал	53,575,260.10	80,108,294.10
35470	Бусад хангамжийн материал	10,032,000.00	10,032,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,153,142,803.82	9,134,292,010.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,153,142,803.82	9,134,292,010.70
392	Биет хөрөнгө	8,912,137,803.82	8,893,623,010.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,514,556,000.00	9,514,556,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(647,308,473.12)	(805,654,406.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,920,000.00	84,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,920,000.00)	(84,920,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,769,313.70	233,094,313.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,324,760.16)	(144,788,379.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	172,552,105.64	190,459,905.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(143,106,382.24)	(174,044,422.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,884,285.70	95,884,285.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,884,285.70)	(15,884,285.70)
393	Биет бус хөрөнгө	241,005,000.00	240,669,000.00
39301	Програм хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(936,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	239,325,000.00	239,325,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,499,072,553.65	9,872,013,543.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,117,982.04	2,158,030.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,117,982.04	2,158,030.00
413	Өглөг	8,117,982.04	2,158,030.00
4136	Бусад өглөг	83,300.00	2,158,030.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,158,030.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,490,954,571.61	9,869,855,513.93
51	Засгийн газрын хувь оролцоо	9,490,954,571.61	9,869,855,513.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	816,099,394.39	816,099,394.39
51101	Өмч: - төрийн	499,974,394.39	499,974,394.39
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	316,125,000.00	316,125,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	8,671,297,440.79	9,050,198,383.11
51210	Өмнөх үеийн үр дүн	8,671,297,440.79	8,671,297,440.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	378,900,942.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,557,736.43	3,557,736.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,499,072,553.65	9,872,013,543.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,496,384,964.00	2,660,363,186.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,089,500.00	536,003,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,089,500.00	536,003,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,089,500.00	536,003,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,609,500.00	31,279,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,480,000.00	504,723,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,484,295,464.00	2,124,359,886.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,919,464.00	60,036,526.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,036,526.09
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	553,614,700.00	704,419,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	553,614,700.00	704,419,200.00
1330	Төсвийн захирагчдаас	888,761,300.00	1,359,904,160.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	888,761,300.00	1,359,904,160.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,779,764,095.01	2,281,462,243.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,779,764,095.01	2,281,462,243.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,775,611,726.23	2,047,545,552.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,615,272.52	981,939,024.64
210101	Үндсэн цалин	512,542,438.98	702,701,138.43
210102	Нэмэгдэл	178,400,988.53	122,561,733.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,471,000.00	68,033,844.70
210104	Урамшуулал	14,200,845.01	88,642,307.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,618,961.14	129,461,700.06
210201	Тэтгэврийн даатгал	63,090,688.82	89,842,700.06
210202	Тэтгэмжийн даатгал	7,132,010.77	9,905,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,658,568.36	7,923,600.00

210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,013.86	1,980,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,455,679.33	19,809,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	545,538,582.04	643,525,368.94
210301	Гэрэл, цахилгаан	8,358,081.04	13,037,901.97
210302	Түлш, халаалт	528,724,538.00	625,879,434.97
210303	Цэвэр, бохир ус	8,455,963.00	4,608,032.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,685,449.00	7,032,900.00
210401	Бичиг хэрэг	1,552,999.00	4,014,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,532,000.00	1,690,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,230,450.00	935,700.00
210404	Ном, хэвлэл	-	192,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,370,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,894,650.00	20,923,205.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	99,000.00
210604	Урсгал засвар	1,894,650.00	20,824,205.00
2107	Томиллот, зочны зардал	499,800.00	14,868,000.00
210702	Дотоод албан томилолт	499,800.00	14,868,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,926,387.15	39,711,760.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,926,387.15	39,711,760.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,832,624.38	210,083,593.12
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	241,285,524.38	210,083,593.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,152,368.78	233,916,691.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	212,548,788.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,274,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	189,574,788.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,384,368.78	21,367,903.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(283,379,131.01)	378,900,942.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(602,120,608.64)	378,900,942.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,494,988,264.00	2,155,639,386.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,692,800.00	31,279,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,692,800.00	31,279,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,609,500.00	31,279,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,609,500.00	31,279,500.00
120009	Бусад орлого	83,300.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,484,295,464.00	2,124,359,886.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,919,464.00	60,036,526.09
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,952,964.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,036,526.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,966,500.00	-
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	553,614,700.00	704,419,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	553,614,700.00	704,419,200.00
1330	Төсвийн захирагчдаас	888,761,300.00	1,359,904,160.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	888,761,300.00	1,359,904,160.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,489,215,459.44	2,146,176,542.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,489,215,459.44	2,146,176,542.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,485,063,090.66	1,912,363,850.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,615,272.52	981,939,024.14
210101	Үндсэн цалин	512,542,438.98	702,701,138.43
210102	Нэмэгдэл	178,400,988.53	122,561,733.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,471,000.00	68,033,844.70
210104	Урамшуулал	14,200,845.01	88,642,307.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,618,961.14	129,461,700.00
210201	Тэтгэврийн даатгал	63,090,688.82	89,842,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,132,010.77	9,905,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,658,568.36	7,923,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,013.86	1,980,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,455,679.33	19,809,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	537,503,900.00	673,055,296.29
210301	Гэрэл, цахилгаан	8,358,081.04	13,037,901.97
210302	Түлш, халаалт	520,689,855.96	655,409,362.32
210303	Цэвэр, бохир ус	8,455,963.00	4,608,032.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,369,300.00	5,878,900.00

210401	Бичиг хэрэг	1,210,302.00	3,904,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,182,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,230,450.00	854,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,125,750.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	620,798.00	-
2105	Нормативт зардал	1,134,000.00	1,134,000.00
210503	Нормын хувцас, zeөлөн эдлэл	1,134,000.00	1,134,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,700,000.00	25,536,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,040,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	9,996,000.00
2107	Томилолт, зочны зардал	499,800.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	499,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,308,050.00	88,288,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,308,050.00	88,108,930.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,313,807.00	6,570,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,313,807.00	6,570,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,152,368.78	233,812,691.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	212,444,788.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	700,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,274,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	189,702,788.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,384,368.78	21,367,903.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,384,368.78	21,367,903.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,772,804.56	9,462,843.95
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,680,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,680,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,680,000.00	-
223001	Бусад хөрөнгө	1,680,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,680,000.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,092,804.56	9,462,843.95
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,092,804.56
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,092,804.56	18,090,528.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	499,974,394.39	3,557,736.43	(5,484,979.05)	498,047,151.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	499,974,394.39	3,557,736.43	(5,484,979.05)	498,047,151.77
C07	Тайлант үеийн үр дүн	316,125,000.00	-	9,774,629,400.33	10,090,754,400.33
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	3,557,736.43	8,671,297,440.79	9,490,954,571.61
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	3,557,736.43	8,671,297,440.79	9,490,954,571.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	3,557,736.43	8,671,297,440.79	9,490,954,571.61
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	378,900,942.32	378,900,942.32
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	3,557,736.43	9,050,198,383.11	9,869,855,513.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангила л	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,092,804.56	(4,092,804.56)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,128,199,400.00	2,124,872,638.43	3,326,761.57	99.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,128,199,400.00	2,124,872,638.43	3,326,761.57	99.8
210	Бараа, үйлчилгээний зардал	1,919,171,800.00	1,912,427,850.43	6,743,949.57	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,537,500.00	981,939,024.14	16,598,475.86	98.3
210101	Үндсэн цалин	702,703,100.00	702,701,138.43	1,961.57	100.0
210102	Нэмэгдэл	140,340,800.00	122,561,733.18	17,779,066.82	87.3
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	60,258,000.00	68,033,844.70	(7,775,844.70)	112.9
210104	Урамшуулал	95,235,600.00	88,642,307.83	6,593,292.17	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,561,800.00	129,461,700.00	100,100.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	89,942,800.00	89,842,700.00	100,100.00	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,905,300.00	9,905,300.00	(0.00)	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	7,923,600.00	7,923,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,980,700.00	1,980,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,809,400.00	19,809,400.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	694,419,200.00	673,055,296.29	21,363,903.71	96.9
210301	Гэрэл цахилгаан	33,119,700.00	13,037,901.97	20,081,798.03	39.4
210302	Түлш, халаалт	638,769,900.00	655,409,362.32	(16,639,462.32)	102.6
210303	Цэвэр, бохир ус	22,529,600.00	4,608,032.00	17,921,568.00	20.5
2104	Хангамж, бараа материалын зардал	5,879,700.00	5,878,900.00	800.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,084,200.00	3,904,200.00	(2,820,000.00)	360.1
210402	Тээвэр (шатахуун)	860,000.00	600,000.00	260,000.00	69.8
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,914,400.00	854,700.00	1,059,700.00	44.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,320,000.00	520,000.00	800,000.00	39.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	701,100.00	-	701,100.00	-
2105	Нормативт зардал	1,134,000.00	1,134,000.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,134,000.00	1,134,000.00	-	100.0
2106	Эд хогшил худалдан авах	25,566,600.00	25,536,000.00	30,600.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,066,600.00	13,040,000.00	26,600.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,996,000.00	4,000.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	57,003,000.00	88,352,930.00	(31,349,930.00)	155.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,823,000.00	88,172,930.00	(31,349,930.00)	155.2
210806	Мэдээллийн технологийн зардал	180,000.00	180,000.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	6,570,000.00	6,570,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,570,000.00	6,570,000.00	-	100.0
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	209,027,600.00	212,444,788.00	(3,417,188.00)	101.6
213204	Бусад урсгал шилжүүлэг	209,027,600.00	212,444,788.00	(3,417,188.00)	101.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	700,000.00	700,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,274,000.00	21,274,000.00	-	100.0
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	186,285,600.00	189,702,788.00	(3,417,188.00)	101.8
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	768,000.00	768,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	764,455,700.00	791,098,426.09	(26,642,726.09)	103.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	704,419,200.00	699,782,400.00	4,636,800.00	99.3
132001	Орон нутгийн төсвөөс	704,419,200.00	699,782,400.00	4,636,800.00	99.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	31,279,500.00	(31,279,500.00)	-
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	31,279,500.00	(31,279,500.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,036,500.00	60,036,526.09	(26.09)	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,036,500.00	60,036,526.09	(26.09)	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,092,804.56	(4,092,804.56)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,090,528.51	(18,090,528.51)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	54.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Монгол Туургатан театр нь үндэсний соёл урлагаа уламжлал шинэчлэлээр баяжуулан хөгжүүлж, хүн амд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, бүх талын тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, орон нутгийн хэмжээнд бүх чиглэлийн тэргүүлэх үйл ажиллагаа явуулдаг театр болох, мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийн чанарыг сайжруулж, уламжлалт үндэстэн ястны бахархалт уран бүтээлүүдээр урийн санг баяжуулан, үзэгчдийн хүртээл болгох зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус театр тайлант онд шинээр 2 концерт, 1 хүүхдийн жүжиг, сэргээн тоглосон дуурь 2, драмын жүжиг 1, хүүхдийн жүжиг тоглож 1 нийт 7 уран бүтээл тавьсан байна. Гаднын 74 арга хэмжээ зохион байгуулсан байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 зорилт 30 арга хэмжээтэй боловсруулан, хэрэгжүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Монгол туургатан театр нь үндэсний соёл урлагаа уламжлал шинэчлэлээр бататган хөгжүүлж, хүн амд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн нийгмийн оюуны хэрэгцээг хангах чиг үүрэг бүхий Соёл урлагийн газарт санхүүгийн тайлангаа нэгтгэдэг Соёлын яамны харьяа төрийн байгууллага юм.

Төв аймгийн Монгол туургатан театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг баталсан.
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн

ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 376,471.0 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,092.8	18,090.5	13,997.7
Авлага	2,348.6	22,525.2	20,176.6
Бараа материал	339,488.3	700,635.8	361,147.5
Үндсэн хөрөнгө	9,153,142.8	9,134,292.0	(18,850.8)
Нийт хөрөнгө	9,499,072.5	9,875,543.5	376,471.0
Богино хугацаат өр төлбөр	8,118.0	2,158.0	(5,960.0)
Засгийн газрын хувь оролцоо	499,974.4	499,974.4	-
Эздийн өмчийн бусад хэсэг	316,125.0	316,125.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,557.7	3,557.7	-
Хуримтлагдсан үр дүн	8,671,297.4	9,053,728.4	382,431.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,499,072.5	9,875,543.5	376,471.0

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Авлагын данс 20,176.6 мянган төгрөгөөр өссөн нь тулш халаалтын зардал илүү төлөлт үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 361,147.5 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газраас 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор нийт 297,200.0 мянган төгрөгийн хувцас шилжин ирсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 18,850.8 мянган төгрөгөөр буурсан Засаг даргын Тамгын газраас 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотой 181,207.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 10,025.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус орлогод авч, элэгдлээрээ буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,814,476.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлыг тус тус өсгөж 2,128,199.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс цалин нэмэгдсэн, байр ашиглалтын зардлын дүн өссөн зэрэг өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 313,723.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,128,199.4 мянган төгрөгийг олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,392,570.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 29,500.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 502,370.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилт 704,419.2 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд 2,124,872.6 мянган төгрөг буюу 99,8 хувьтай зарцуулсан байна. Тайлант оны эцэст орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 21,367.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэ лт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,131,576.6	1,131,576.6	-	100.00
2	80214 Уран бүтээл хийлгэх	20,000.0	19,997.4	2.6	99.99
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	208,327.6	208,327.6	0.0	100.00
4	81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	32,666.5	32,666.5	(0.0)	100.00
5	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	-	32,639.1	(32,639.1)	100.00
6	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	704,419.2	683,051.3	21,367.9	96.97

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний зардал, урсгал засвар, бичиг хэрэг, шуудан холбоо, гэрэл цахилгаан, тээвэр шатахууны зардлуудад 740,293,1 мянган төгрөгөөр төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 727,203.2 мянган төгрөг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,799,764.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 26,696.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цалингийн зардлаас 16,598.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой 21,363.9 мянган төгрөг хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж 10 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 75,052.1 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв орхигдуулсан зүйлгүй оруулдаг байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 79,724.0 мянган төгрөгийн цахим баримт илүү, 7,779.5 мянган төгрөг дутуу шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар баримт материал ирүүлээгүй тул завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 51,642.6 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 1 зөвлөмж, 1 албан шаардлага, 2 акт өгсөн байна. Биеллэлт 50 хувьтай хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлага, өглөгийн данстай холбоотой албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 1,431.7 мянган төгрөгийн акт төвлөрүүлээгүй зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	
Зөвлөмж	1	31,809.7	-	-	0	
Албан шаардлага	1	8,037.7	-	-	0	
Акт	2	11,798.2	2	10,366.5	100	
Нийт дүн	4	51,642.6	2	10,366.5	50	

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг эсэх, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болон худалдан авалтын хэтрүүлэн зарцуулсан эсэхийг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 63,376.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрч 3,530.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 22,525.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 16,280.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 21,041.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Авлага, өглөгийн талаар холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд нийт 22,525.2 мянган төгрөгийн авлагатай гарсан, үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт, УСНББОУС1 Санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулсан”, гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх төлбөрийн акт хүргүүлэв.

5.2 Албан шаардлага

1. Үндсэн хөрөнгийн асуудал

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогын горим сорил хэрэгжүүлэхэд аймгийн 100 жилийн ойн баяр наадмын арга хэмжээтэй холбоотой Аймгийн Засаг даргын Тамгын газраас хүлээн авсан үндсэн хөрөнгөөс 15,180.0 мянган төгрөгийн Засаг даргын Тамгын газраас хүлээн авсан хангахгүй, үндсэн хөрөнгийг кодлож бүртгэлжүүлээгүй, 1,100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу орлого хүлээн авсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.2-т “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлуулаагүй 19,610.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй үнэн зөв батлуулдаг байх, төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийх.

2. Өмнөх оны аудитын асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар 11,798.2 мянган төгрөгийн акт тавьснаас 10,366.4 мянган төгрөг төлж, 1,431.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар өгсөн актын төлбөрийг хуулийн хугацаанд төлдөг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/												
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан	Заглуулаагүй	Тоо		Дүн		
Бараа материалын орлогыг давхардуулж авсан	1	3,530.0			1	3,530.0							
Дүн	1	3,530.0			1	3,530.0	1	3,530.0					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагдах шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	
Авлаг үүсгэж ажилласан.	1	22,525.2	1	22,525.2								
Шинэ хөрөнгө сар болоогүй эвдэрсэн, хөрөнгө дутуу орлогдсон.	1	16,280.0			1	16,280.0						
Өмнөх оны аудитын актын төлбөр 1,431.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	1	1,431.7					1	1,431.7				
Худалдан авах ажиллагаанд төлөвлөөгүй худалдан авалт хийсэн.	1	19,610.0					1	19,610.0				
Дүн	4	59,846.9	1	22,525.2	1	16,280.0	2	21,041.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй гүйлгээг дутуу оруулсан байна.	1	75,052.1			1	75,052.1	
Дүн	1	75,052.1			1	75,052.1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Хөрөнгийн тооллогын горим сорил хэрэгжүүлэхэд аймгийн 100 жилийн ойн баяр наадмын арга хэмжээтэй холбоотой Аймгийн засаг Даргын тамгын Газраас хүлээн авсан үндсэн хөрөнгөөс 15,180.0 мянган төгрөгийн өсгөгч эвдэрсэн, ашиглалтын шаардлага хангахгүй, үндсэн хөрөнгийг кодолж бүртгэлжүүлээгүй, 1,100.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу орлого хүлээн авсан.	1	16,280.0			1	26,280.0	
Дүн	1	16,280.0			1	26,280.0	
Нийт дүн	2	91,332.1			2	91,332.1	



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 89-Н/310516-ТӨА-2024

Зуунмод

САНБ/НА-07А-ТМЗ

Г

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Монгол туургатан театрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тайлант онд 22,525,200 /хорин хоёр сая таван зуун хорин таван мянга хоёр зуун/ төгрөгийн авлагатай гарсан, үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, УСНББОУС1 Санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ**

НЬ:


1. Авлагуусгэж ажилласан 22,525,200 /хорин хоёр сая таван зуун хорин таван мянга хоёр зуун/ төгрөгийг Төв аймгийн Төрийн сан дахь Тө.ХҮ, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Монгол туургатан театрын захирал Д.Намсрайноров, нягтлан бодогч Д.Наранцэнгэл нарт даалгав.

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019050065

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ² ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

С.ОЮУНГЭРЭЛ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 44-НЗТ0516-ТӨА-2024

Зуунмод

202509-СТА-ТМЗ

Г Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол туургатан театрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 87,503,500 /наян долоон сая таван зуун гурван мянга таван зуун/ төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх;

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол туургатан театрын захирал Д.Намсрайноров, нягтлан бодогч Д.Наранцэнгэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 16 өдөр

Дугаар НЗ-14500516-ТВА-2024/1 /2025/НА-СТА-ТМЗ Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол туургатан театрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шинэ хөрөнгө сар болоогүй эвдэрсэн, 16,280,000 /арван зургаан сая хоёр зуун наян мянга/ төгрөгийн хөрөнгө дутуу орлогодсон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгө бүртгэж авах биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол туургатан театрын захирал Д.Намсрайноров, нягтлан бодогч Д.Наранцэнгэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040897